

APU COMPANY  
Absolute. Pure. Unique.

# 2023

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

## ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



Бид бүхий л түвшинд чанарыг эрхэмлэж, хэрэглэгч, харилцагч, хамтрагчдынхаа эрхэм сонголт байна.



Бид хүн, нийгэм ба эх дэлхийд ээлтэй үйл ажиллагаа явуулж, байгальд сэргөөр нөлөөлөх нөлөөллийг алхам бүртээ багасгаж, гэрэлт ирээдүйг хамтдаа цогцлооно.



Бид баяр хөөртэй, дахин давтагдашгүй, нандин сайхан мөчүүдийг түгээнэ.

## ҮНЭТ ЗҮЙЛС



### АМЖИЛТ ӨӨД ХАМТДАА

- Бид хамтын ажиллагаа, хамтын шийдвэр гаргалт, хүн бүрийн оролцоог бүрдүүлж, нээлттэй харилцааг эрхэмлэдэг.
- Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг бий болгон үр дүнтэй хамтран ажилладаг.
- “Би” бус “Бид” зарчмыг дээдэлдэг.
- Бид аливаад хамтдаа ялахын төлөө ажилладаг ба win-win зарчмыг дээдэлдэг.



### БУСДЫГ ДЭЭДЛЭН ЭРХЭМЛЭ

- Хүнсний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд ханган ажилладаг.
- Бид байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулж, эх дэлхийгээ хайрлан дээдэлдэг.
- Бид нийгэмдээ үйлчилж, нийгмийн хөгжил дэвшилд өөрийн үнэтэй хувь нэмрийг оруулдаг.
- Бид хууль дүрмээ чандлан сахиж, шударга ёсыг эрхэмлэн ажилладаг.



### СУРАЛЦ. НЭЭ. ХӨГЖ.

- Бид мэдлэг, ур чадварыг эрхэмлэн дээдэлдэг. Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг.
- Хэрэглэгч, харилцагч, зах зээлийн талаарх мэдлэг, судалгаа, шинжилгээнд үндэслэн аливаа шийдвэрийг гаргадаг.
- Бид үргэлж шинийг судалж, эрэлхийлж, шинэ зах зээл, шинэ хил хязгаарыг нээхийг эрмэлздэг.



### УЛАМЖЛАЛАА ХҮНДЭЛ, ШИНИЙГ БҮТЭЭ






- Бид үргэлж уламжлалаа дээдэлж, шинийг эрэлхийлж, шинэ шийдэл, шинэ бүтээгдэхүүн, шинэ үнэ цэнийг бүтээдэг.
- Ажилтан бүр нээлттэй санал санаачилга гаргаж, түүнийгээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг.
- Бид бусдаас түрүүлж, бусдаас түргэн хөдөлдөг.



### ҮЛГЭРЛЭН МАНЛАЙЛ

- Бид хааш тэмүүлж, юунд зорьж буйгаа мэддэг.
- Бид салбар, зах зээл бүртээ манлайлахын төлөө ажилладаг.
- Аливаад эзний ёсоор хандаж, бусдыгаа уриалан дууддаг.
- Хүн бүр манлайлагч байхыг хүсдэг, бас чаддаг итгэдэг.
- Хүн бүр бусдыг үлгэрлэн манлайлж, нөлөөлж нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэдэг.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ



## Онцлох үйл явдал

### МОНГОЛЫН ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ СУРТАЛЧИЛСАН АНХНЫ "ДИЖИТАЛ ШОШГО" -ЫГ ТАНИЛЦУУЛЛАА.

АПУ компани нийгэмд эерэг өөрчлөлтийг уриалах "Соёлоор гоёно" төслийн хүрээнд хариуцлагатай хэрэглээний талаар мэдлэг, ойлголтыг дижитал шошгоор дамжуулан хэрэглэгчдэд хүртээмжтэйгээр хүргэх зорилтын дагуу Хариуцлагатай хэрэглээг сурталчилсан Монголын анхны дижитал шошгыг олон нийтэд танилцууллаа.



### МОНГОЛД АНХ УДАА БОЛГАР ТАРАГ

"АПУ ДЭЙРИ Монгол сүүний үйлдвэр" нь Болгар улстай хамтран ажиллах хамтын ажиллагааны гэрээнд үзэглэлээ. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Болгар тарагны хөрөнгийг албан ёсны эрхтэйгээр Монгол улсад анх удаа оруулж ирэх цорын ганц эрхийг авсан юм.



### ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

АПУ ХК Тогтвортой хөгжлийн тайлангаа бие даасан байдлаар анх удаа бэлтгэн гаргалаа. Энэхүү тайлан нь Байгаль орчин, нийгэмдээ сайн нөлөөлөл үзүүлэх, хариуцлагатай хэрэглээг сурталчлах, хүн төвтэй засаглал бэхжүүлэх, мөн хамт олны өсөн дэвжих орчныг тэргүүнд тавих зорилтыг таниулсан юм.



## ЭКСПОРТЫН ТОЙМ



Казахстан улс руу экспорт хийх гэрээ байгуулан ажиллаж байна.



БНХАУ-н хил нээгдсэнтэй холбоотойгоор Сэнгүр брэндээ хэрэглэгчдэдээ дахин хүргэж эхэллээ.



Олон улсын нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүл болох "The Spirit Business" дээр АПУ компанийн бүтээгдэхүүнүүд тэр тусмаа Чингис Хаан брэнд дэлхийн архины зах зээлд цахиур хагалж байгаа талаар тусгай сурвалжилгаараа дамжуулан нийтэллээ.

ОХУ-ын Москва, Санкт Петербург хотод Чингис Хаан брэндийг таниулан борлуулж эхэллээ.



Тайландын татваргүй барааны дэлгүүрээр Чингис Хаан, Соёмбо, Эден брэндүүдийг борлуулж олон улсын нислэгээр үйлчлүүлж байгаа хэрэглэгчдэд хүргэсээр байна.



## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Балансын бүтцэд орсон өөрчлөлтүүд:

Харилцагч нараа дэмжих, экспортын үйл ажиллагааг тэлэх бодлогыг үргэлжлүүлэн идэвхтэй хэрэгжүүлснээр авлагын дүн нэмэгдсэн ба бараа материалын нөөцийн өсөлт, хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотойгоор эргэлтийн хөрөнгө өнгөрсөн оны сүүлчтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байлаа.

Хөдөө аж ахуйн салбарыг дэмжсэн үнэ цэн авчрах төслүүд, Дижитал концепт ХХК-ийн үйл ажиллагааны тэлэлттэй холбоотой хөрөнгө оруулалтууд хийгдэж буйгаас хамааран холбогдох өр төлбөр, гадаад санхүүжилтийн зээлийн хэмжээ өссөн байна.

		2022 Q4	2023 Q2 Аудитлагдаагүй
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	351,152.0	433,663.4
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	490,982.4	531,350.2
<b>Нийт хөрөнгө</b>	сая.төг	<b>842,134.4</b>	<b>965,013.5</b>
Өр төлбөр	сая.төг	208,557.2	307,075.3
Эздийн өмч	сая.төг	633,577.2	657,938.2
<b>Нийт өр төлбөр ба Эздийн өмч</b>	сая.төг	<b>842,134.4</b>	<b>965,013.5</b>

## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Орлого үр дүн:

2023 оны 2-р улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад АПУ Групп компанийн цэвэр борлуулалтын орлого 32%-иар өссөн ба цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеийнхээс 13%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Борлуулалтын орлогын өсөлт нь сүү сүүн бүтээгдэхүүн, Дижитал концепт ХХК болоод Экспортын борлуулалтын өсөлтөөс хамаарсан. Энэ онд олон улсын зах зээлийг тэлэх зорилготой үйл ажиллагаануудыг тасралтгүй идэвхтэй хэрэгжүүлэн Ази дахь борлуулалтын өсгөх зорилготойгоор БНХАУ-д охин компанийн үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.

Мөн Монгол үндэсний уламжлал, орчин үеийн инновацыг хослуулсан шинэлэг чанартай брэнд бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх, байгууллагын хүн төвтэй бодлогын хүрээнд ажилчдын цалин хангамж, тасралтгүй хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хийгдэж буй хүн нийгэмд хандсан хөтөлбөрүүд нь удирдлага маркетингийн зардлуудыг өсгөхөд гол нөлөө үзүүлжээ.

		2022 Q2 Аудитлагдаагүй	2023 Q2 Аудитлагдаагүй
Борлуулалтын орлого (цэвэр)	сая.төг	391,076.1	517,884.8
Борлуулалтын өртөг	сая.төг	201,479.7	291,330.7
<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	сая.төг	<b>189,596.4</b>	<b>226,554.1</b>
Үйл ажиллагааны зардал	сая.төг	82,995.9	137,075.0
<b>Үйл ажиллагааны ашиг</b>	сая.төг	<b>106,600.5</b>	<b>89,479.1</b>
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	сая.төг	(1,416.8)	1,647.8
<b>Татварын өмнөх ашиг</b>	сая.төг	<b>105,183.8</b>	<b>91,126.9</b>
Орлогын албан татварын зардал	сая.төг	23,052.4	19,454.8
<b>Татварын дараахь ашиг (алдагдал)</b>	сая.төг	<b>82,131.4</b>	<b>71,672.2</b>

Үйл ажиллагааны маржин	27%	17%
Цэвэр ашгийн маржин	21%	14%

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, удирдлагын багийг удирдан ажилладаг. 2023 оноос удирдлагын багийг 2 шатлалтай зохион байгуулж, Гүйцэтгэх захиралд шууд харьяалагдах захирлуудын тоо 11 байсныг 7 болгон цөөлсөн.



Цэвээнжавын  
**ЭРДЭНЭБИЛЭГ**  
Гүйцэтгэх захирал



Дандарова  
**АРИУНА**  
Экспорт эрхэлсэн захирал



Батсайханы  
**ЦАЦРАЛ**  
Борлуулалт, маркетинг  
эрхэлсэн захирал



Жаргалсайханы  
**ИЧИНХОРЛОО**  
Захиргаа, Хүний нөөц  
эрхэлсэн захирал



Добрев  
**НИКОЛАЙ**  
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа  
эрхэлсэн захирал



Гончигийн  
**ЭНХБИЛЭГ**  
Санхүү эрхэлсэн захирал,  
Төслийн удирдлагын  
захирал



Галсумъяагийн  
**БАЯРМАГНАЙ**  
АПУ Дэйри ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал



Батсайханы  
**ГАНТИГ**  
Стратеги эрхэлсэн захирал

## АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ

Тайлант хугацаанд АПУ Групп компанийн бүтцэд өөрчлөлт гараагүй.

# APU COMPANY

Absolute. Pure. Unique.



**APU DAIRY**  
Absolute. Pure. Unique.



**APU TRADING**  
Absolute. Pure. Unique.



**CHINGGIS KHAN  
INTERNATIONAL LIMITED**



**爱啤酒**  
Enter Mongolia APU trading company

Хараат компани

**DIGITAL  
CONCEPT**

## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

ХАТУУЛАГ БАГАТАЙ  
БҮТЭЭГДЭХҮҮН

Эх орны шилэгдмэл сортын улаанбуудайгаар дэлхийн өндөр түвшний Heineken стандартын дагуу “Агар” брэндийг шинээр гаргаж, “Алтантүрүү” брэндийг шинэчлэн гаргав. Мөн орчин үеийн залуусын шинэ хэрэглээний хандлагад нийцэх хатуулаг багатай “Ooze” холимог RTD төрлийг шинээр танилцуулж, “Elix Neo” хатуулаг бууруулсан бүтээгдэхүүнийг танилцууллаа.

ХАРИУЦЛАГАТАЙ  
ХЭРЭГЛЭЭ

Шинэ үеийн хэрэглээний хандлагад нийцүүлэн “Нийслэл” брэндийн амт болон савлагааг бүрэн шинэчилж “Нийслэл Lite” болон “Нийслэл Super Lite” болгон төрөлжүүлж хариуцлагатай хэрэглээг дэмжих “Соёлоор гоёно” платформын хамт танилцуулав. Монголын анхны “Боргио” брэнд өөрийн limited edition савлагаагаар хэрэглэгчид хүрэв.



## ИННОВАЦ – ШИНЭЧЛЭЛ

Эх орныхоо эмийн ургамлыг үндэсний бахархалт брэнд болтол нь хөгжүүлэн боловсруулж, шинэ инновац шингээн орчин үеийн технологийн дагуу АПУ компани Монголын хамгийн анхны NFT бүтээгдэхүүн болох ТЭРЭЛЖ СЭЛЭНГЭ “limited edition” зах зээлд гаргалаа. Мөн тоор жимсний амттай САХАРЫН АГУУЛАМЖГҮЙ оргилуун хийжүүлсэн усыг хэрэглэгчдэдээ шинээр хүргэлээ.

Инновац, шинэчлэл шингэсэн эх орны бүтээгдэхүүн.





## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед эрсдэлийн удирдлагын чиг хандлага ч мөн ялгаагүй шинэчлэгдэн цар хүрээгээ тэлж байгаа ба бид тогтвортой хөгжилд чиглэсэн эрсдэлийн удирдлагын оновчтой арга барилыг хэрэгжүүлэх замаар байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй засаглалыг бэхжүүлж, бизнест үнэ цэн нэмэх ажлуудад илүүтэй анхааран ажиллаж байна.

Удаан үргэлжилсэн геополитикийн асуудал нь эдийн засгийн тодорхойгүй байдлыг өдөөж улмаар Монгол улсын төдийгүй компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд шууд болон дам нөлөөллүүдийг учруулсан хэдий ч олон улсын дипломат харилцаа сайжирсан, урд хөршийн хил гааль нээгдсэн зэрэг үйл явдлууд нь Монгол улсын гадаад худалдааны тэнцэл эерэг гарах, экспортын гол бүтээгдэхүүний гарц нэмэгдэх, үүнийгээ дагаад бизнесийн орчин сэргэх зэрэг эерэг төсөөллийг авч ирээд буй. Үүний нөлөөгөөр АПУ ХК нь эрсдэлийн удирдлагыг цаг алдалгүй оновчтой хэрэгжүүлж, аливаа тодорхойгүй нөхцөл байдлыг уян хатнаар даван туулах, мөн санхүү, зардлын ухаалаг хэмнэлтийг тогтвортойгоор хэрэгжүүлэх, багц бүтээгдэхүүний оновчлолыг сайжруулж үйлдвэрлэлийн тасалдлаас урьдчилан сэргийлэхэд анхаарч нийгэмдээ ээлтэй олон, олон төсөл хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлсээр байгаа билээ.

Мөн өөрсдийн хэрэгжүүлсэн дотоодын эрсдэлийн удирдлагын программын тусламжтайгаар АПУ групп компанийн бүхий л алба нэгжүүдийн хүрээнд эрсдэлийг тодорхойлох, нарийвчилсан судалгаа анализ хийх, эрсдэлийг оновчтой үнэлж, зэрэглэх, эрсдэлийн стратегийн дагуу гүйцэтгэлийн мөшгөлт хийх замаар аливаа эрсдэлийг удирдан ажиллаж байна.

- Эдийн засаг/Санхүү
- Байгаль орчин
- Нийгэм
- Геополитик
- Нийцэл
- ★ Боломж
- Шууд бус нөлөөлөл
- Шууд нөлөөлөл

ЭРСДЭЛИЙН ТОХИОХ МАГАДЛАЛ /УЧИР ШАЛТГААН/

● **ГЕОПОЛИТИКИЙН АСУУДАЛ БА САНХҮҮ/ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Худалдан авах чадвар буурч, амьжиргааны зардал нэмэгдэх  
 Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг нэмэгдэх  
 Тээвэр ложистикийн зардал өсөх  
 Нийлүүлэлтийн тасалдал, ТЭМ хоцрогдол үүсэх

● **МӨНГӨНИЙ ХАТУУ БОДЛОГО /ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ҮР НӨЛӨӨ**

Өндөр хүүгийн зардал- Хөрвөх чадвар буурах  
 Тэтгэвэр тэтгэмж, цалин хангамжийн өсөлт- Инфляц өндөр хэвээр хадгалагдах

● **БАЙГАЛИЙН ГАМШИГТ ҮЗЭГДЭЛ & ЦАГ УУРЫН ГЭНЭТИЙН ӨӨРЧЛӨЛТ**

El Nino /Газрын гадаргуу дахь хэт халалт, цаг уурын өөрчлөлт /  
 Үер ус, ган

● **ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ**

ХХА-н гаалийн албан татвараас чөлөөлөгдөх  
 Согтууруулах ундааг импортлох, экспортлох хилийн боомтыг тогтоох тухай тогтоол батлагдав.  
 Нийгмийн эмзэг байдал  
 Нийгмийн сөрөг хандлага, халдлага

● **НИЙГМИЙН НӨЛӨӨЛӨЛ**

Нийгмийн сөрөг хандлага, халдлага  
 Хэрэглээний шилжилт, хэрэглэгчийн худалдан авах чадвар



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00-15:40 цагийн хооронд 92.43%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав:

1. АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2022 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг хуралд оролцож, хүчинтэй санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар хуралд оролцож, хүчинтэй санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.99%-ийн саналаар батлав.

Үүнд:

### Ердийн гишүүн


1. П.Батсайхан
2. Б.Батбаяр
3. Сергей Громов
4. Д.Миеэгомбо
5. Кеннет Чу
6. Сэн И-Ин

### Хараат бус гишүүн

1. Ё.Гэрэлчулуун
2. О.Одбаяр
3. Ж.Үнэнбат

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчид  
(2023 оны 04 сарын 07-ны өдрийн байдлаар)



Өнгөрөгч оны мөн үетэй харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Steppe Beverage KFT-ийн эзэмшлийн хувь 0.06%-аар буурчээ.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгосон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.



**ПҮРЭВИЙН  
БАТСАЙХАН**  
ТУЗ-ийн ердийн гишүүн  
бөгөөд ТУЗ-ийн дарга

Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч  
Скайтел ХХК-ийн ТУЗ-ийн дарга,  
гишүүн, АПУ ХК-ийн 0.08%-ийн  
хувьцаа эзэмшигч



**БҮРЭНТОГТОХЫН  
БАТБАЯР**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Шунхлай групп ХХК-ийн Санхүү  
эрхэлсэн захирал  
АПУ ХК-ийн 0.05%-ийн хувьцаа  
эзэмшигч



**СЕРГЕЙ ГРОМОВ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**КЕННЕТ ЧУ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азия Пасифик  
компанийн Ази-Номхон далайн  
бүсийг хариуцсан Гүйцэтгэх  
захирал  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**СЭН И-ИН**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азия Пасифик компанийн  
Ази-Номхон далайн бүсийн Хууль  
эрхзүй хариуцсан захирал  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**ДОРЖИЙН  
МИЕЭГОМБО**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

"ЕС" ХХН-д зөвлөх  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**Одончимэдийн  
ОДБАЯР**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ард даатгал ХК, Ард холдинг ХХК,  
Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн  
гишүүн  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**ЁНДОН-ОЙДОВЫН  
ГЭРЭЛЧУЛУУН**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч  
АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**ЖИГЖИДИЙН  
ҮНЭНБАТ**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй



**ЧАДРААБАЛЫН  
АРИУНСАН**  
ТУЗ-ийн нарийн бичгийн  
дарга


АПУ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 13-ны өдрийн 23/03 тоот тогтоолоор 2022 оны хоёрдугаар хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан нэгж хувьцаанд ₮44 (дөчин дөрвөн төгрөг)-ийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэн, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр (2023 оны 04 сарын 07)-өөр тогтоож, ногдол ашгийг 2023 оны 12 сарын 31-ний өдрийн дотор төлөхөөр тогтов.

Тус ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан ба таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

### Ногдол ашгийн хуваарилалт (2018 оноос хойш)



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

ТУЗ-ийн 2022 оны 05 сарын 18-ны өдрийн №22/10 тоот тогтоолоор баталсан Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд компанийн засаглалын дараах 18 бодлого, дүрэм журам, зааврыг үе шаттайгаар Кодексийн

зарчимд нийцүүлэн шинээр болон шинэчлэн батлах ажлыг төлөвлөн, хэрэгжүүлж байна.

Баримт бичгийн нэр	Батлах хэлбэр	Хэрэгжилт
<b>А Дүрэм, бодлогын баримт бичиг, заавар болон бусад:</b>		
1. Бизнесийн ёс зүйн дүрэм	Шинээр баталсан	Хэрэгжсэн
2. Залгамж халааны бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
3. Цалин, урамшууллын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
4. Ногдол ашгийн бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
5. Эрсдэлийн удирдлагын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
6. Дотоод аудитын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
7. Дотоод хяналтын бодлого	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
8. Комплайнсын хяналтын бодлого/заавар	Шинээр батлах	Боловсруулж байна
9. Тогтвортой хөгжлийн бодлого	Шинээр батлах	Боловсруулж байна
10. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого	Шинээр баталсан	Хэрэгжсэн
<b>Б Дотоод журам:</b>		
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
12. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
13. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
14. ТУЗ-ийн дэргэдэх хороод (Аудит, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх)-ын журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
15. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
16. Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам	Шинэчлэн баталсан	Хэрэгжсэн
17. Дотоод хяналт, комплайнс, дотоод аудитын нэгж эсхүл ажилтны үйл ажиллагааны журам	Шинээр батлах	Боловсруулж байна
18. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам	Шинээр батлах	Боловсруулж байна

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг 2023 оны 04 сарын 01-ний өдрийн байдлаар давтан хийж, нэгдсэн үр дүнг 2022 оны үр

дүнтэй харьцуулсан байдлаар дор танилцуулав. Үнэлгээний асуулгын дагуух дэлгэрэнгүй тайлан МХБ болон Компанийн цахим хуудсанд байршсан болно.

### АПУ ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

	Гарчиг	2022.06.16-ны өдрийн байдлаар			2023.04.01-ний өдрийн байдлаар			2022/2023 өсөлт
		Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	9	75%	12	12	100%	25%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8	80%	10	9	90%	10%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%	6	6	100%	0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%	6	6	100%	17%
5	Эрсдэлийн удирдлага	8	6	75%	8	7	88%	13%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	3	50%	6	6	100%	50%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	75%	8	8	100%	25%
8	Компанийн соёл	6	3	50%	6	6	100%	50%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%	10	8	80%	0%
	Нэгдсэн дүн	72	54	75%	72	68	94%	19%
		2. Дунд засаглалтай			1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй			1 түвшин ахив.

Тайлбар:

1. Нийт онооны 90% болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
2. 70-89% байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
3. 50-69% байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
4. 49% болон түүнээс доош бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

## ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн хувьцааны хаалтын ханш оны эхэнд ₮1,491 байсан бол хагас жилийн эцэст ₮1,277 болж буурсан. Зах зээлийн үнэлгээ 2023 оны эхний хагас жилийн эцэст 1.36 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4%-аар буурсан үзүүлэлттэй байна.

АПУ ХК-ийн хувьцаа идэвхтэй арилжигдсан үнэт цааснаас тоо ширхгийн эрэмбээр арвантавдугаарт, үнийн дүнгийн эрэмбээр тавдугаарт жагсжээ.

### Арилжааны мэдээ





## СОЁЛООР ГОЁНО

### ҮНДЭСНИЙ ИХ ӨВ “СОЁЛООР ГОЁНО”

АПУ ХК нь үндэсний бөхийн спортыг дэмжих замаар өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улсын Арслан Б.Орхонбаяр, Монгол Улсын Харцага Т.Өсөх-Ирээдүй нартай урт хугацаанд хамтран ажиллахаар боллоо. Бид уламжлал, өв соёлоо эрхэмлэн дээдэлж үндэсний спортууд болох шагайн харваа, сур харваа, хурдан морь, үндэсний бөх тэргүүтэй олон төрөлд бахархал болсон тэргүүлэх тамирчидтай хамтран ажиллаж байна.



### “ӨВ СОЁЛООР ГОЁНО” – АЛТАЙН ЯТГА

Алтайн ятга хэмээх эртний хөгжмийн зэмсгийн уянгалаг аялгууг уртын дуу, орчин үеийн Регги урлагтай холбон үр хойчдоо өвлүүлэхээр АПУ компани Соёлоор гоёно төслийн хүрээнд бүтээж, олон түмэндээ толилууллаа. Уг хөгжмийн зэмсгийг анх 2008 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ажилтан, профессор Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Батбаяр нар Ховд аймгийн Манхан сумын Жаргалант хайрханы хадны оршуулгаас олон тооны эд өлгийн зүйл гарсны дотор хамгийн гайхамшигтай олдвор нь модоор урласан чавхдаст хөгжмийн зэмсэг байж. Нэн эртний, 1400 жилийн өмнөх соёл иргэншлийг тээсэн ятгын урлагийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх үйлсийг өдгөө СТА Д.Ганпүрэв зорин ажиллаж, уг санаачилгыг Монгол соёл, уламжлалд элэгтэй Недерланд улсын иргэн Рован Лий Хартцукер дэмжин, энэхүү өвийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд зориулан олон нийтээс хөрөнгө татах ажлыг өөрийн цахим хуудсаараа дамжуулан эхлүүлсэн байдаг. Эдгээр санаачилгуудыг нэгтгэн орчин үеийн хөгжмийн бүтээл бүтээх санаачилгыг АПУ компани Соёлоор гоёно төслийн хүрээндээ гарган, Ятгачин Ч.Мөнх-Эрдэнэ (МУГЖ), Уртын дуучин Б.Алтанжаргал (СТА), Регги дуучин Мачо, Алтайн ятгачин: Rowan Lee Hartsuiker нарын уран бүтээлчдийн уран хослолоор дамжуулан бүтээлээ.



Дэлхийд үетэйгээ хосгүй хөл үнэт нийлүүлэн, өвөөрөө өв бахархаж, орчин соёлоор гоёцгоо!

1400 жилээс улбаатай соёлын гайхамшигтай үнэт өвөө өвлүүлэн, соёлоор гоёцгоо.

## ЦАГААН ХУВЬСГАЛ



### ЦАГААН ХУВЬСГАЛ

АПУ компани Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг сүүний салбарт “Цагаан хувьсгал” хийх уриалгаар дэмжин үргэлжлүүлэх саналыг дэвшүүлж, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, шингэн сүүний нийлүүлэлтийг сайжруулахад дараах ажлуудаар дэмжин ажиллаж байна.

### МАЛЧИД , ФЕРМЕРҮҮДИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ

АПУ ДЭЙРИ Монгол сүүний үйлдвэр нь малчид фермерүүдийн тогтвортой амьжиргааг дэмжих хүрээнд цаг уурын хэцүү нөхцөл байдал, өвөлжилтийн хүндрэлтэй цаг үед шингэн сүүг өндөр үнээр авч, нэн шаардлагатай байгаа 150 гаруй тонн малын тэжээлээр хангалаа



### ИМПОРТЫГ ОРЛОХ МОНГОЛ БЯСЛАГ

Сэлэнгэ аймгийн Мандал суманд АПУ ХК-ийн Спирт Бал бурам ХХК 50 дах жилдээ үйл ажиллагаа явуулж буй бөгөөд энэхүү 50 жилийн ойн босгон дээр Монгол улсдаа хүчин чадлаараа хамгийн томд тооцогдох европын холбооны стандартыг бүрэн хангасан байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон шинэ бяслагийн үйлдвэрээ ашиглалтад орууллаа.



2016 оноос хойш хийсэн судалгаанд Монгол улсад жилд 3000 тонн нийт 102 тэрбум төгрөгийн бяслагийг гадны улс орнуудаас импортоор оруулж ирдэг бөгөөд тэдгээр импортын бяслагийн дийлэнх нь дуураймал буюу аналог бяслаг байдаг төдийгүй сүүний орц байхгүй хүнсний нэмэлт бүтээгдэхүүн ихээр ашигласан байдаг. Тиймээс бид Голланд, Швейцар, Англи зэрэг улсуудын бяслаг үйлдвэрлэх технологиос Монгол үнээний сүүнд тохируулан Монголд бяслаг үйлдвэрлэх технологийг нутагшуулан ийнхүү шинэ бяслагийн үйлдвэрээ байгууллаа.



## СПОРТ, УРЛАГ ХАМТЫН АЖИЛЛАГАА



### FC ULAANBAATAR

АПУ ХК нь хөлбөмбөгийн спортын хөгжлийг дэмжих замаар залуучуудын эрүүл амьдралын хэв маяг, зөв дадал хэвшлийг бий болгох зорилгоор “ФС УЛААНБААТАР” хөлбөмбөгийн шигшээ багийг 9 дэх жилдээ дэмжин, хамтран ажиллаж байна. 2023 оны хагас жилийн хувьд “УЛААНБААТАР” КЛУБ 12 ЖИЛИЙН ДАРАА ДЭЭД ЛИГИЙН АВАРГА болж МХБХ-ны нэг тэрбумын шагналын сантай 2022-2023 оны улирлын “Моби Дээд Лиг” 2022 оны 08-р сарын 23-наас өнөөдрийг хүртэл анх удаагаа 27 тойргийн тоглолтууд хийгдсэнээс 59 оноотой тэргүүлж, аваргын болзол хангаж, ДЭЭД ЛИГИЙН АВАРГААР ШАЛГАРЛАА.



### ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГ

АПУ ХК нь залуучуудын эрүүл мэндийн зохистой дадал, хэвшлийг бий болгох зорилгоор сагсан бөмбөгийн спортын хөгжилд хувь нэмэр оруулан “Монголын Сагсан Бөмбөгийн Холбоо” /МСБХ/-ны Үндэсний дээд лигийг урт хугацаандаа дэмжин хамтран ажиллаж байна. Тухайлбал АПУ ХК ийн Сэнгүр брэнд нь 2013 оноос Үндэсний Сагсан Бөмбөгийн Холбооноос зохион байгуулдаг Монголын хамгийн том, чансаа өндөртэй Супер Лиг болон Үндэсний 21 аймгийн лигийн ерөнхий ивээн тэтгэгчээр тасралтгүй 9 жил ажиллаж, спортод хайртай залуусын сонирхол, хүсэл тэмүүллийг ийнхүү дэмжсээр байна. Энэхүү спортын хамтын ажиллагааны үр дүнд спортын лигийн маркетинг, менежментийн үйл ажиллагааг цоо шинэ түвшинд хүрсэн бөгөөд АПУ ХК-ийн зүгээс ҮСБХ-той хамтран NBA-н медиа сувгийн гол контентууд болох TOP 10, Highlights, Shaqtin’ A fool зэргийг анхлан нэвтрүүлж, Лигийн нээлт, All Stars, Play Off, Final тоглолтуудыг мэргэжлийн өндөр түвшинд олон нийтэд хүргэж ажиллаж байна



### ШАЙБТАЙ ХОККЕЙН ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

АПУ ХК нь Шайбтай хоккейн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг дэмжин ажиллалаа. Монгол улсад анх удаа зохион байгуулагдсан Шайбтай хоккейн Ази болон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг дотоодын брэндүүдээрээ дэмжин ажиллаж залуусын соёлтой хэрэглээ, хариуцлагатай хэрэглээг бий болгох чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллалаа.




### БАЛЕТЫН ХӨГЖЛИЙН САН

АПУ ХК нь хүүхэд залуучуудад Балетын урлагийг түгээн дэлгэрүүлж, цаашдын хөгжилд нь томоохон хувь нэмэр оруулах үүднээс Монголын Балетын Үндэсний Сургууль/ National Ballet School of Mongolia-тай хамтран балетын урлагаар сонирхон хичээллэдэг сурагч нарт бүтэн нэг жилийн сургалтын төлбөрийг тэтгэлэг болгон гардууллаа. Энэхүү сургалтын тэтгэлгийг Монголын балетын үндэсний сургуулийн тайлан тоглолт болох “ХАВРЫН БАЯР”-аар гардуулан өгсөн бөгөөд тэтгэлэгт шалгарсан авьяаслаг сурагчид болох Монголын балетын үндэсний сургуулийн сурагч И.Ундрам, Анаргэрэл, Г.София нартаа цаашдын урлагийн замналд нь өндөр амжилт хүсье.



### ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД БОЛГАР ТАРАГ МОНГОЛД

“АПУ ДЭЙРИ Монгол сүүний үйлдвэр” нь Болгар улстай хамтран ажиллах хамтын ажиллагааны гэрээнд үзэглэлээ. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Болгар тарагны хөрөнгийг албан ёсны эрхтэйгээр Монгол улсад анх удаа оруулж ирэх цорын ганц эрхийг авсан бөгөөд уг эрхийг авсан Азийн 2 дах улсын нэг болж байна. Болгар улс бол тарагны соёлоороо дэлхийд алдартай орон бөгөөд Болгарчууд урт наслалтаараа тэргүүлэгч орнуудын нэг юм. Тэдний урт наслалтын нууц чухам юундаа байгааг 1907 онд Нобелийн шагналтан Оросын эрдэмтэн, хүн төрөлхтний насжилт, дархлал судлаач Иля Мэчников /Ilya Metchnikoff/ нь “Lactobacillus Bulgaricus” бактерийг шинжлэх ухааны түвшинд анх судалсан ба Болгар тарагны хөрөнгөнд байх ашигтай бактери нь хүний дархлалыг дэмждэг, эрүүл мэнд, хөгшрөлтийн эсрэг үзүүлэх ач тусыг өөрийн олон бүтээлдээ тодотгож өгүүлсэн байдаг. Ийнхүү болгар тарагны хөрөнгө дэлхий дахинаа алдартай болж тухайн улсыг зорин Болгар таргийг уудаг жуулчдын тоо ч нэмэгджээ. Иймд АПУ Дэйри-Монгол сүүний үйлдвэр нь хэрэглэгч түмэндээ зориулан эрүүл мэндэд ашиг тустай бүтээгдэхүүнийг чанар стандартын өндөр түвшинд үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна.



### АПУ ДЭЙРИ - МОНГОЛ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР ДЭЛХИЙН СҮҮНИЙ ӨДӨР- ХҮҮХДИЙН БАЯР

Хүүхэд бүр эрүүл саруул өсөн торниход сүү сүүн бүтээгдэхүүний оруулах үр нөлөө өндөр гэдгийг мэргэжилтнүүд онцолдог. Иймд сүүний хэрэглээ, ач холбогдлыг эцэг эх, хүүхэд багачуудад таниулах зорилгоор “Дэлхийн Сүүний Өдөр”, “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь “Дэлхийн Сүүний өдөр” болон хүүхдийн баярын өдөрт зориулан сүүний ашиг шим, зохист хэрэглээг сурталчлан таниулах арга хэмжээг 2 дох жилдээ амжилттай зохион байгууллаа.



### “НАРНЫ ХҮҮХДҮҮД-3” ЭКО НОГООН ШИНЭ ЦЭЦЭРЛЭГ

АПУ ХК “Нарны хүүхдүүд-3” эко ногоон шинэ цэцэрлэгийн барилгын хөрөнгө бүрдүүлэх арга хэмжээг дэмжин хамтран ажиллаа. Энэхүү арга хэмжээ нь “Вэлүү сан”-гаас “Gobi Gallop Gala” нэртэйгээр зохион байгуулагддаг бөгөөд ийнхүү 10 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. “Вэлүү сан” нь Нарны хүүхдүүд 1,2-р цэцэрлэгийг амжилттай бүтээн байгуулж 2013 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж өдгөө 300 гаруй хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсролыг олгож байна. Энэхүү шинэ цэцэрлэг баригдсанаар тус сангийн цэцэрлэгийн хүчин чадал 3 дахин нэмэгдэх бөгөөд сургуулийн өмнөх боловсролын хүртээмж сайжрах юм. Нийгэмд чиглэсэн ажлуудыг амжилттайгаар хэрэгжүүлж чаддаг “Вэлүү сан”-гийн нийт хамт олондоо баяр хүргэн талархал илэрхийлье



## ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

### СУРГАЛТ ХӨГЖИЛ

АПУ компани нь ажилчдынхаа сурч хөгжих, гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулхаас гадна туршлага солилцох зорилгоор ажилчин солилцоогоор ажиллах боломжийг хангаж өгдөг. Тухайлбал Үйлдвэрлэл, үйл ажиллагааны газрын хүрээнд Инженер болон техникийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор 2023 оны 04 сард Савлалтын үйлдвэр болон Тайгер үйлдвэрийн автоматик болон механикийн техникч, инженер болох 8 ажилтныг Хятад улсын Тайсан хот дах Кронесийн сургалт, лабораторийн төвд 7 өдрийн сургалт, семинарт хамрууллаа. Энэхүү сургалтаар ажилтнууд мэргэжлийн шинэ технологи, чиг хандлагатай танилцаж, лаборатори дадлагыг хийж, олон улсын үйлдвэрлэлийн чиг хандлага, дагаж мөрдөж буй стандарт зэрэгтэй танилцсан юм.



### "HEINEKEN"- ТУРШЛАГА



АПУ ХК нь дэлхийн топ үйлдвэрлэгч HEINEKEN компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, туршлага, чанар стандартыг бүхий л түвшиндээ нэвтрүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд дэлхийн зах зээлд томоохон тоглогч болж буй HEINEKEN компанид ажилчин солилцоогоор

ажиллах боломжийг компанийн зүгээс нээлттэй олгодог. Тухайлбал АПУ компанийн төлөвлөлтийн ажилтан Э.Намуунцэцэг Малайз улсын нийслэл Куала Лумпурт байрлалтай Хайнекен компанид Борлуулалт, үйл ажиллагаа төлөвлөлтийн чиглэлээр туршлага солилцон 6 сарын хугацаанд ажиллаж, өөрийн туршлага мэдлэгээ сайжруулан, олон улсын чанар стандарт, борлуулалт үйлдвэрлэлийн төлөвлөлттэй холбоотой төслүүд дээр амжилттай ажиллалаа.



Олон улсын түвшний чадварлаг хүний нөөц

АПУ ХК нь дэлхийн топ үйлдвэрлэгч HEINEKEN компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, туршлага, чанар стандартыг бүхий л түвшиндээ нэвтрүүлэн ажиллаж байна.



## ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

### ХҮНИЙ НӨӨЦ

Хүний нөөцийн салбарын олон улсын чуулга уулзалт 2023 оны 03 сард Малайз улсын Куала Лумпур хотод болж өнгөрсөн ба энэхүү үйл ажиллагаанд АПУ групп компанийн хүний нөөцийн газрыг төлөөллүүдийг хамрууллаа. Энэхүү чуулга уулзалт нь олон улсын компаниудын сайн жишээ, туршлагыг танилцуулсан төдийгүй дэлхийн хүний нөөцийн бодлого, хүн төвтэй чиглэсэн төслүүд, амжилттай явж буй сайн жишээнүүдийг онцолж, хүргэсэн юм.



### "APU LIFE" 2.0 ХӨТӨЛБӨР

АПУ компани нь ажиллагсад, хамт олныхоо дунд "Эерэг амьдралын хэв маягийг түгээцгээе" уриатайгаар "APU Life" хөтөлбөрийг 2022 оноос эхлэн санаачлан хэрэгжүүлсээр байна. 2023 онд "APU Life" хөтөлбөрийн хүрээнд "PEOPLE EXPERIENCE" нээлттэй өдөрлөг, Ажилтнууд хоорондын мэдээ мэдээлэл солилцох, харилцаа холбоог сайжруулах боломж олгох зорилгоор "COFFEE TIME" -АПУ группийн бүх байршилд зохион байгууллаа. Мөн Групп компаниудын ажилтнуудын хоорондын нөхөрсөг харилцааг бий болгох, харилцан туршлага солилцох, багаар хамтран ажиллах болон хувь хүний чадварыг сайжруулах, бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийн шинэ үйлдэл, дадал зуршлыг бий болгох тогтмол гүйгчдийг бий олноор бий болгон бусдад үлгэр дуурайлал, нөлөөллийг бий болгох зорилгоор Шунхлай марафоныг үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 6 сард зохион байгуулж аваргуудаа шалгарууллаа.




## 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨДӨРЛӨГ




АПУ ХК нь “Дэлхийн Усны өдөр” -ийг тохиолдуулан Эко Орчин ХХК, Мултипак ХХК, “Бичил нахиа”, “Хаягдал хувцсаа үнэ цэнэ болгоё” төслийн багтай хамтран “Эх Дэлхийгээ Хайрлаж, Усаа хэмнэе!” өдөрлөгийг нийт компанийн амжилтнуудаа зориулан амжилттай зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр АПУ компани нь “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-д хүрэхийн төлөө цэвэр усны эх үүсвэрийг хайрлан хамгаалах, нөөцийг зүй зохистой ашиглах, хэмнэх, усыг дахин ашиглах үүднээс нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны хэрэглээг бууруулахад чиглэсэн бодлогыг танилцуулж, сурталчлахаас гадна Монгол орны хүрээлэн буй орчны тулгамдсан асуудал ба гарц, Хөрсөн бүрхэвчийн суурь ойлголт, хөрсөн бүрхэвчийн эрүүл ахуйн түүний ач холбогдол, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар илтгэл, хэлэлцүүлэг хийж, танилцууллаа.



## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ БУУРУУЛАХ БОДИТ ШИЙДЭЛ.

- Нийгэм, байгаль орчиндоо ээлтэй
- Агаарын бохирдол үүсгэхгүй
- Жилд 3000тн түүхий нүүрсийг хэрэглээнээс халсан
- Энергийн алдагдлыг бууруулна
- Байгальд хаягдах хог хаягдлыг бууруулсан
- Зуухны ашигт үйлийн коэффициент 95% болж нэмэгдсэн уурын зуухны төслийг амжилттай хэрэгжүүлээ.



## ОРОН НУТГИЙН ХОГ АНГИЛАН ЯЛГАХ АЖЛЫН ХҮРЭЭГ ТЭЛЭВ

АПУ Компани тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд шилний хог хаягдлыг бууруулж, байгальд үүсэх сөрөг нөлөөллийг багасгах ажлыг үе шаттайгаар хийсээр ирсэн.

Хөвсгөл нуур орчимд цуглардаг эзэнгүй хог хаягдлыг 20 жилийн турш цэвэрлэж, ангилан ялгаж яваа “Хогийн Сайнаа” хочтой “Хүн байгаль бүлэг”-ийн ахлагч Ж. Сайнбаяртай энэ удаад хамтран ажиллалаа. Хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг үйл хэргээрээ сурталчилж, нийгэм болон байгаль орчны төлөө үлгэрлэн манлайлж буй энэхүү бүлгийн өдөр тутмын ажлыг хөнгөвчлөх, ажлын цар хүрээг нэмэх зорилгоор хог тээвэрлэх ачааны машин худалдан авалтанд дэмжлэг үзүүлэв.



## АПУ ХК ӨДӨР ТУТМЫН ТҮГЭЭЛТДЭЭ ЦАХИЛГААН МАШИНЫГ НЭВТРҮҮЛЛЭЭ

Дэлхий даяар бүхий л салбар бензин, дизель хөдөлгүүртэй автомашин үйлдвэрлэх, ашиглахаас татгалзаж эко буюу цахилгаан машин руу шилжин байгаль орчин, олон нийтийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй сонголтуудыг хийсээр байна. Үүний дагуу зах зээл, нөлөөллийн судалгаан дээр үндэслэн АПУ ХК Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд салбартаа анх удаа түгээлтийн үйл ажиллагаандаа цахилгаан машиныг нэвтрүүллээ. Авто замын түгжрэл хамгийн өндөр буюу Улаанбаатар хотын төвийн бүсийн түгээлтэд хоёр цахилгаан автомашин 2023 оны 6-р сарын 2-ноос эхлэн түгээлтийн оргил ачааллын үетэй давхцан ийнхүү гарч байна.

АПУ ХК 2019 оноос хойш дотоод хэрэгцээндээ цахилгаан машин нэвтрүүлсэн бол өнөөдрөөс эхлэн хотын төвийн бүсээр явуулж буй нь энэ юм. Эдгээр машин нь хүлэмжийн хий ялгаруулдаггүй бөгөөд агаарын бохирдол, цаашлаад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг АПУ ХК-ийн үе шаттай хэрэгжүүлж буй стратегийн нэгээхэн хэсэг болж байна. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/613 тоот

захирамжийн дагуу хотын тээвэрт оролцож буй цахилгаан машин дугаарын хязгаарлалтад хамаарахгүй учир түгээлтийг тасралтгүй бөгөөд цаг алдалгүй үргэлжлүүлэх, ингэснээр сэлгэж явуулах дизель хөдөлгүүрт машины хэрэгцээг бууруулах юм.

Машины тос масло солих шаардлагагүй, дизель түлш ашиглахгүй учир ашиглалтын зардлыг урт хугацаанд хэмнэж, үр ашгийг нэмэгдүүлэх олон талын ач холбогдолтой. Мөн цахилгаан машины дотор бүхээг дуу чимээ багатай тул түгээгч, жолооч нарт ядралт багатай хөдөлмөрийн орчныг бүрдүүлж өгнө.

Ирэх 5 жилийн хугацаанд түгээлтийн үйл ажиллагаандаа 30 хүртэлх тооны бүрэн цахилгаан машинаар парк шинэчлэлтээ хийхээр төлөвлөн ажиллаж байна. Энэхүү ажил нь АПУ ХК байгаль орчин, эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллөө сайжруулах, байгууллага бүтээмж өндөртэй, ажилтнууд ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм.





### “ГАЙХАМШИГТ ЖОЛООЧ УУСАН БОЛ ЖОЛОО БАРЬДАГГҮЙ”

“АПУ” ХК нь нийгмийн манлайллын “Соёлоор гоёно” төслийн дэд хэсэг болгон хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд компанийн тогтвортой хөгжлийн бодлогын нэг хэсэг болох “Хариуцлагатай хэрэглээ”-г бий болгох зорилгоор замын хөдөлгөөний аюулгүй байдал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын эсрэг “Гайхамшигт жолооч – Уусан бол жолоо барьдаггүй” хөтөлбөрийг хэрэгжүүлж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохын хор уршгийг нийгэмд таниулах, зөрчлөөс сэргийлэх арга зам, жолоодлогын үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр “АПУ” ХК, Тээврийн Цагдаагийн алба, “UB” байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



### “ГАЙХАМШИГТ ЖОЛООЧ УУСАН БОЛ ЖОЛОО БАРЬДАГГҮЙ” – ЗҮҮН ХАРААД



АПУ ХК-ийн охин компани болох Спирт Бал Бурам ХХК 50 жилийн ойн хүрээндээ “UBCab” - Онлайн такси үйлчилгээг Сэлэнгэ аймгийн Мандал суманд нэвтрүүлэн, хариуцлагатай хэрэглээг сурталчлах нээлттэй өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр Зүүнхараагийн иргэд, жолоочид АПУ компанийн санаачлан

хэрэгжүүлж буй “Гайхамшигт жолооч- Уусан бол жолоо барьдаггүй” нөлөөллийн аянд нэгдэж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх амлалтыг өгсөн бөгөөд “UB Cab” такси дуудлагын үйлчилгээ тус орон нутагт нэвтэрч эхэллээ.

### “ИХ ХОТЫН БАЯР LITE SHOW 2023”



Соёлтой хэрэглээний трендийг түгээгч “Их хотын баяр LITE show 2023”-аар 2000 гаруй залуус “Гайхамшигт жолооч- Уусан бол жолоо барьдаггүй” аянд нэгдэж, амлалтаа өгч, шинэ соёлыг хамтдаа түгээлээ. Наадмын үеэр АПУ ХК “Нийслэл” шар айргийн “LITE” нэртэй хатуулаг багатай хувилбарыг шинээр зах зээлд танилцуулсан ба Монголын анхны хариуцлагатай хэрэглээг уриалсан “Дижитал шошго”-тойгоор анх удаа хүрч, хариуцлагатай хэрэглээний соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор энэ төрлийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд веб цэс нэмэлтээр хөгжүүлж QR хэлбэрээр бүтээгдэхүүний шошгон дээр байршуулалт хийхийн зэрэгцээ хариуцлагатай хэрэглээний зөвлөмж, мэдээллүүдийг шинээр зах зээлд гаргаж буй бүтээгдэхүүний шошгон дээр ийнхүү байршуулж өгч эерэг нөлөөлөлд манлайлж байна.



### МОНГОЛЫН ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ СУРТАЛЧИЛСАН АНХНЫ “ДИЖИТАЛ ШОШГО” –Г ТАНИЛЦУУЛЛАА.

АПУ компани нийгэмд эерэг өөрчлөлтийг уриалах “Соёлоор гоёно” төслийн хүрээнд хариуцлагатай хэрэглээний талаар мэдлэг, ойлголтыг дижитал шошгоор дамжуулан хэрэглэгчдэд хүртээмжтэйгээр хүргэх зорилтын дагуу Хариуцлагатай хэрэглээг сурталчилсан Монголын анхны дижитал шошгыг олон нийтэд танилцууллаа.

АПУ компани бүтээгдэхүүндээ инновацийг тогтмол шингээн ажилладаг бөгөөд хариуцлагатай хэрэглээг таниулах зорилгоор Монголын анхны дижитал шошгыг нэвтрүүлээ. Алдарт ХУРД хамтлагийн 30 жилийн ойн баярт зориулан гаргасан Боргио брэндийн HURD LIMITED EDITION бүтээгдэхүүнд тус шошгыг анхлан байрлуулсан.

Ингэснээр АПУ компанийн нийгэмд эерэг өөрчлөлтийг уриалах “Соёлоор гоёно” хөтөлбөрийн хүрээнд хариуцлагатай хэрэглээний талаар мэдлэг, ойлголтыг дижитал шошгоор дамжуулан хэрэглэгчдэд хүртээмжтэйгээр хүргэх юм. Энэхүү хөтөлбөрийн дэд төсөл болох ‘Гайхамшигт жолооч – Уусан бол жолоо барьдаггүй’ кампанит ажлаар дамжуулан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох эрсдэлийг бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Дэлхийн шингэн хүнсний томоохон брэндүүд дижитал шошгыг бүтээгдэхүүндээ ашигладаг олон улсын жишгийн дагуу АПУ компани нэг алхам урд алхаж, өөрийн бүтээгдэхүүндээ нэвтрүүлж буй нь энэ юм. Уг шошгоор дамжуулан соёлтой, хариуцлагатай хэрэглэгчийн зан төлөвийг АПУ компани уриалан дэмжиж байна.





# APU COMPANY

Absolute. Pure. Unique.

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот - 17040, Чингисийн өргөн чөлөө - 14,

Утас: +976 - 7600 2220, Факс: +976 - 11 - 343063
















[www.apu.mn](http://www.apu.mn)

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

АПУ ХК-ийн 2023 оны эхний хагас жил

<u>Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/</u>			
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>			
Тайлагнах хугацаа	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ УБГД: 000165753, РД: 2702673 ҮЦКод: АРУ Утас: 11-344336		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Шингэн хүнсний үйлдвэрлэл		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тооширхэг	1,064,181,553		
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Санхүү, тайлагналын албаны дарга Ж.Оюумаа, Комплайнсын мэргэжилтэн Б.Мягмар, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан		
1.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтүүдийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгө	351,152,026,000	433,663,365,558
	Эргэлтийн бус хөрөнгө	490,982,398,000	531,350,184,196
	<b>Нийт хөрөнгө</b>	<b>842,134,424,000</b>	<b>965,013,549,754</b>
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	129,643,932,000	178,706,897,022
	Урт хугацаат өр төлбөр	78,913,248,000	128,368,450,450
	Эздийн өмч	633,577,244,000	657,938,202,282
	<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>842,134,424,000</b>	<b>965,013,549,754</b>
Орлогын тайлан	<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
	Борлуулалтын орлого (цэвэр)	850,239,813,487	517,884,786,826
	Борлуулалтын өртөг	(478,212,778,487)	(291,330,652,237)
	Нийт ашиг ( алдагдал)	372,027,035,000	226,554,134,590
	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>154,112,211,000</b>	<b>91,126,941,083</b>
	Орлогын татварын зардал	(28,214,649,000)	(19,454,754,242)
	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>125,897,562,000</b>	<b>71,672,186,841</b>
	Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох	144,692,756,000	84,153,016,181
	Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	(18,795,194,000)	(12,480,829,340)
	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>66,117,907,000</b>	<b>(540,339,867)</b>
	<b>Нийт орлогын дүн</b>	<b>192,015,469,000</b>	<b>71,131,846,974</b>
	Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох	210,810,663,000	83,612,676,314
	Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох	(18,795,194,000)	(12,480,829,340)

		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>		Эздийн өмч		
		Хувьцаат капитал	106,297,000	106,297,500
		Нэмж төлөгдсөн капитал	338,094,870,000	338,094,869,200
		Нэгдлийн нөөц	(112,795,804,000)	(112,795,804,000)
		Дахин үнэлгээний нөөц	156,566,882,000	156,250,410,906
		Гадаад валютын хөрвүүлгийн	703,518,000	163,178,133
		Хуримтлагдсан ашиг	220,738,413,000	258,437,011,883
		<b>Нийт эздийн өмч</b>	<b>603,414,176,000.00</b>	<b>640,255,963,622</b>
		Хяналтын эрхгүй хувь оролцоо	30,163,068,000.00	17,682,238,660
		<b>Нийт дүн</b>	<b>633,577,244,000.00</b>	<b>657,938,202,282</b>
		<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	112,645,636,000.00	87,999,143,814.54
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(92,776,665,000.00)	(45,698,497,406.39)
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(60,638,967,000.00)	20,637,940,312.60
		<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(40,769,996,000.00)</b>	<b>62,938,586,720.75</b>
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	77,277,746,000.00	38,365,107,000.00
		Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бууралт болон валютын ханшийн өөрчлөлт	1,857,357,000.00	-
		<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>38,365,107,000.00</b>	<b>101,303,693,720.75</b>
2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>	АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар АПУ Групп компанийн 2023 оны 1 дүгээр хагас жилийн тайланг хэлэлцэн батална.		
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>			
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<b>Харьцаанууд</b>	<b>2022</b>	<b>2023.Q2</b>
		Нийт ашгийн хувь	44%	44%
		Үйл ажиллагааны ашгийн хувь	18%	18%
		Цэвэр ашгийн хувь	15%	14%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	21%	11%
		Нэгж хувьцаанд ногдох ашиг	136,120.56	78,659.12
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	<b>Харьцаанууд</b>	<b>2022</b>	<b>2023.Q2</b>
		Эргэлтийн харьцаа	2.71	2.43
		Түргэн хөрвөх чадварын	0.77	0.85
		Өр болон өөрийн хөрөнгийн	0.33	0.47
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний торол хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Инфляци болон гадаад валютын ханшийн өсөлт, нийлүүлэлтийн гинжин сүлжээний үнийн өсөлтөөс хамаарч түүхий эд материалын үнэ өсч улмаар бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өсөхөд шууд нөлөөлж байна. Үүний эсрэг ажлын капиталын удирдлага болон санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах замаар хариу арга хэмжээ авч ажиллаж байна.		
3.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	Байхгүй		

4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>										
	<ul style="list-style-type: none"> <li>- Их хэмжээний хэлцэл тухайн тайлант хугацаанд гараагүй</li> <li>- Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээг жилийн эцсийн тайлангаар толилуулна (2022 оны жилийн эцсийн тайлангийн тодруулгад тусгасан байнгын шинжтэй сонирхлын зөрчилтэй хэлцлээс өөр хэлцэл хийгдээгүй болно).</li> </ul>										
5.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</p>										
	<p>Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.</p>										
6.	<p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p>										
	<p style="text-align: center;"><b>Хувьцаа эзэмшигчдийн хурал</b></p> <p>Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00-15:40 цагийн хооронд 92.43%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2022 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг хуралд оролцож, хүчинтэй санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.</li> <li>2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг ТУЗ-ийн дарга 10 сая, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая байхаар хуралд оролцож, хүчинтэй санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 99.99%-ийн саналаар батлав.</li> </ol> <p style="text-align: center;"><b>Төлөөлөн удирдах зөвлөл</b></p> <p>Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 29-ний өдрийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгосон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.</p> <p><b>ТУЗ-ийн бүрэлдэхүүн:</b></p> <table border="0"> <tr> <td data-bbox="295 1220 1364 1413"> <p>ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга <b>ПҮРЭВИЙН БАТСАЙХАН</b> (Инженер мэргэжилтэй) Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч 2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга Хувьцаа эзэмшил: 0.08%</p> </td> <td data-bbox="1364 1220 1522 1413"></td> </tr> <tr> <td data-bbox="295 1413 1364 1570"> <p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР</b> (Эдийн засагч мэргэжилтэй) Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.05%</p> </td> <td data-bbox="1364 1413 1522 1570"></td> </tr> <tr> <td data-bbox="295 1570 1364 1727"> <p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>СЕРГЕЙ ГРОМОВ</b> (Инженер мэргэжилтэй) Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p> </td> <td data-bbox="1364 1570 1522 1727"></td> </tr> <tr> <td data-bbox="295 1727 1364 1919"> <p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>КЕННЕТ ЧУ</b> (Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй) Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал 2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p> </td> <td data-bbox="1364 1727 1522 1919"></td> </tr> <tr> <td data-bbox="295 1919 1364 2098"> <p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>СЭН И-ИН</b> (Хуульч мэргэжилтэй) Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал 2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p> </td> <td data-bbox="1364 1919 1522 2098"></td> </tr> </table>	<p>ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга <b>ПҮРЭВИЙН БАТСАЙХАН</b> (Инженер мэргэжилтэй) Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч 2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга Хувьцаа эзэмшил: 0.08%</p>		<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР</b> (Эдийн засагч мэргэжилтэй) Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.05%</p>		<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>СЕРГЕЙ ГРОМОВ</b> (Инженер мэргэжилтэй) Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>		<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>КЕННЕТ ЧУ</b> (Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй) Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал 2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>		<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>СЭН И-ИН</b> (Хуульч мэргэжилтэй) Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал 2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>	
<p>ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга <b>ПҮРЭВИЙН БАТСАЙХАН</b> (Инженер мэргэжилтэй) Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч 2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга Хувьцаа эзэмшил: 0.08%</p>											
<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР</b> (Эдийн засагч мэргэжилтэй) Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.05%</p>											
<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>СЕРГЕЙ ГРОМОВ</b> (Инженер мэргэжилтэй) Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга 2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>											
<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>КЕННЕТ ЧУ</b> (Нягтлан бодогч, менежмент мэргэжилтэй) Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийг хариуцсан Гүйцэтгэх захирал 2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>											
<p>ТУЗ-ийн ердийн гишүүн <b>СЭН И-ИН</b> (Хуульч мэргэжилтэй) Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал 2020 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Хувьцаа эзэмшил: 0.00%</p>											

ТУЗ-ийн ердийн гишүүн  
**ДОРЖИЙН МИЕЭГОМБО** (Хуульч мэргэжилтэй)  
“ЁС” ХХН-д зөвлөх  
2022 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН** (Эдийн засагч мэргэжилтэй)  
Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч  
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**ОДОНЧИМЭДИЙН ОДБАЯР** (Багш, эрх зүйч мэргэжилтэй)  
Ард даатгал ХК, Ард холдинг ХХК, Монгол шуудан ХК-уудын ТУЗ-ийн гишүүн  
2021 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



ТУЗ-ийн хараат бус гишүүн  
**ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ** (Эдийн засагч мэргэжилтэй)  
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  
Хувьцаа эзэмшил: 0.00%



### Гүйцэтгэх удирдлагын баг

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, удирдлагын багийг удирдан ажилладаг. 2023 оноос удирдлагын багийг 2 шатлалтай зохион байгуулж, Гүйцэтгэх захиралд шууд харьяалагдах захирлуудын тоо 11 байсныг 7 болгон цөөлсөн.

#### Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн:

Гүйцэтгэх захирал  
**ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ**  
Хувьцаа эзэмшил: 0.00%



Санхүү эрхэлсэн захирал, Төслийн удирдлагын захирал  
**ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ**  
Хувьцаа эзэмшил: 0.00%



Экспорт эрхэлсэн захирал  
**АРИУНА ДАНДАРОВА**  
Хувьцаа эзэмшил: 0.00%



Стратеги эрхэлсэн захирал  
**БАТСАЙХАНЫ ГАНТИГ**  
Хувьцаа эзэмшил: 0.00%



Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал  
**НИКОЛАЙ ДОБРЕВ**  
Хувьцаа эзэмшил: 0.00%



Борлуулалт, маркетинг эрхэлсэн захирал  
**БАТСАЙХАНЫ ЦАЦРАЛ**  
Хувьцаа эзэмшил: 0.00%



Захиргаа, хүний нөөц эрхэлсэн захирал  
**ЖАРГАЛСАЙХАНЫ ИЧИНХОРЛОО**  
Хувьцаа эзэмшил: 0.00%



АПУ Дэйри ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
**ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ**  
Хувьцаа эзэмшил: 0.00%



### Бусад эрх бүхий албан тушаалтан

Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс гадна ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч нь компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно. Тайлант хугацаанд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Чадраабалын Ариунсан, Ерөнхий нягтлан бодогчоор Батсуурийн Даваадорж ажиллав. Тус эрх бүхий албан тушаалтнууд компанид хувьцаа эзэмшдэггүй.

### АПУ Групп компанийн бүтэц

Тайлант хугацаанд АПУ Групп компанийн бүтэцэд өөрчлөлт гараагүй.

### Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчид (2023 оны 04 сарын 07-ны өдрийн байдлаар)

Д/д	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	ШУНХЛАЙ ХОЛДИНГ ХХК	596,229,642	56.03
2	HEINEKEN ASIA PACIFIC PTE LTD	266,091,981	25.00
3	STEPPE BEVERAGE KFT	113,885,099	10.70
4	Бусад	87,974,831	8.27

Өнгөрөгч оны мөн үетэй харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Steppe Beverage KFT-ийн эзэмшлийн хувь 0.06%-аар буурчээ.

### Ногдол ашгийн мэдээлэл

ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 13-ны өдрийн 23/03 тоот тогтоолоор 2022 оны хоёрдугаар хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан нэгж хувьцаанд ₮44-ийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэн, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2023 оны 04 сарын 07-ны өдрөөр, ногдол ашгийг 2023 оны 12 сарын 31-ний өдрийн дотор төлөхөөр тогтов. Тус ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан ба таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

### Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт

АПУ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, компанийн засаглалын үнэлгээний тайлангаар 2023 оны 4 сарын 01-ний өдрийн байдлаар тайлагнасан компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн явц болон өөрийн үнэлгээнд өөрчлөлт гараагүй.

### Хувьцааны арилжааны мэдээлэл

АПУ ХК-ийн хувьцааны хаалтын ханш оны эхэнд ₮1,491 байсан бол хагас жилийн эцэст ₮1,277 болж буурсан. Зах зээлийн үнэлгээ 2023 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар 1.36 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4%-аар буурсан байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Эрдэнэбилэг

Албан тушаал: “АПУ” ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ч.Ариунсан ✓

Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ..... *Ч. Ариунсан* .....